



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 8/22

Модот

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалт, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны 2024 оны 06 сарын 24-ны өдрийн 2/2772 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч албан тушаалтай Д.Ганчимэг нь Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн тайлагнаж 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авч ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар урамшуулал олгосугай.

2.Урамшуулалт цалинг 07 дугаар сарын үндсэн цалин дээр тооцож олгохыг нягтлан бодогч (Д.Ганчимэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ